



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/102

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 2021 оны 124 дүгээр тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108-р тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII хуралдааны XII/21 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/13 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Булган сумын 5 дугаар баг 11,16,17,19,104 дүгээр байрны гадна фасадны зураг төсөв боловсруулах ажлыг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр “Эчо дизайн” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Эчо дизайн” ХХК (Г.Мэндбаяр)-д үүрэг болгосугай.

3. Булган сумын 5 дугаар баг 11,16,17,19,104 дүгээр байрны гадна фасадны зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтийг тухайн арга хэмжээний батлагдсан төсвөөс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010043